

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТҮНХАГЛАЛ



Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR I, II циклээс хүний эрхийн тогтолцоог бэхжүүлэх хүрээнд нийт 13 зөвлөмж хүлээж авснаас 5 зөвлөмжийг хэрэгжсэн хэмээн үзлээ. Энэ хүрээнд иргэний оролцоог баталгаажуулах, хүн амын тодорхой бүлгийн эрхийг хангах, хамгаалах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр шинээр баталсан хууль тогтоомжийг иргэний нийгмийн зүгээс сайшааж байгаа болно.

ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

Хүний эрх хамгаалагчдын тухай хуультай болох зөвлөмжийг хэрэгжүүлэх санаачилгыг 2017 онд ХЭҮК гаргасан хэдий ч хууль одоогоор батлагдаагүй байна. Дэлхийд ховордсон ирвэсийн амьдардаг орчинд олгосон уурхайн лицензийг цуцлуулахаар тэмцэж, эрүүл мэнд, аюулгүй байдлаараа заналхийлэлд хэд хэдэн удаа өртөж байсан хорь гаруйхан настай байгаль хамгаалагч сураггүй алга болж, цогцос нь олоходоо “амиа хорлосон” гэх, авлигын тухай бичиж байсан сэтгүүлч эмэгтэй гэртээ гэнэт нас барахад “гаднын нөлөөгүй унаж, золгүй тохиолдлоор нас барсан” гэсэн дүгнэлт гарсан нь манай улсад хүний эрхийн хамгаалагчдад тохиолдож буй аливаа халдлага зохих ёсоор шалгагдахгүй байгаагийн илрэл юм.

ХЭҮК-ын тухай хуулийг Парисын зарчимд нийцүүлэх чиглэлээр хуулийн төсөлд олон чухал зохицуулалт туссан. Гэвч ХЭҮК-ын гишүүнд тавих шаардлагыг “хууль зүйн өндөр мэргэшилтэй” гэсэн нь олон улсын шаардлагад нийцэхгүй байна.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж хүлээн авсан ч энэ чиглэлээр тодорхой алхам хийсэнгүй. Түүнчлэн, 2012 оны сонгуулийн дараа ХЗДХЯ-ны сайдын шийдвэрээр тус яаман дээр ажиллаж байсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хорооны ажлын алба байхгүй болж, Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах Үндэсний Хорооны үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилт зогссон. Түүнээс хойш хөтөлбөрийг сэргээх арга хэмжээг аваагүй байгаа бөгөөд ХЭҮК-ын тухай хуулийн төслийг дагаж гарах хуулийн төсөлд тус хөтөлбөрийг хүчингүй болгох төсөл санаачлаад байна.

Ялгаварлан гадуурхалт болон жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг хуультай болох, УИХ-ын гишүүдэд хариуцлага тооцох буюу эгүүлэн татах тухай хуулийн зохицуулалттай болох зөвлөмжүүд хэрэгжээгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан ЗГ дэмжсэнээр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл (ҮАБЗ)-ийн зөвлөмжөөр шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, Авилгатай тэмцэх газар (АТГ)-ын дарга, дэд даргын бүрэн эрхийг түдгэлзүүлэх өөрчлөлтийг холбогдох хуульд орууллаа. Гэвч Монголын шүүх, прокурорын байгууллага ашигт малтмалын лиценз, газрын наймаа, тендертэй холбоотой, авлигын олон хэргийг шийдэж чадахгүй байгаа. Түүнчлэн шүүх, прокурорыг ажилладаг болгоход тус тусынх нь хуулийг боловсронгуй болгож хэрэгжилтийг хангахын оронд ЗГ, Ерөнхийлөгч, УИХ-ын даргаас бүрддэг ҮАБЗ-ийн зөвлөмжөөр халж солин асуудлыг шийдэх гэж буй оролдлого нь зарчимд нийцэхгүй байна.

Хүний эрхийн үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийн нэг нь сонгууль зөвхөн мөнгөтэй хүмүүсийн ажил болж сонгох, сонгогдох эрх хэрэгжихгүй, улс төрийн нам сонгуулийн ажлаа хувийн бизнесийн хандив, төрийн албан тушаалын арилжаагаар санхүүжүүлж, хөгжлийн бодлого боловсруулах, олон нийтэд ардчиллын боловсрол түгээх үүргээ хэрэгжүүлэх чадавхгүй, авлигын хэрэгт холбогдсон хүмүүсээс салж чадахгүй байгаа болон УИХ-ын гишүүд ардчилал, хүний эрхийн зарчим, ёс зүйн хэм хэмжээг зөрчихөд хариуцлага хүлээлгэх, эгүүлэн татах зохицуулалтгүй байгаа явдал юм.

Авлига албан тушаалын гэмт хэргийг шалгаж, хариуцлага тооцох байдал туйлын хангалтгүй байна. Тухайлбал, “Төрийн албыг 60 тэрбум (22.3 сая ам.дол)-аар худалдах тухай”, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийг албан тушаалын эрх мэдлээ ашиглаж хуваан авсан тухай” зэрэг дуулиант хэргүүд замхрах байдалд ороод байна. АТГ-ын судалгаагаар 2016-2018 онд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр нийт 29 хэргийг хаажээ.

Төрөөс хүч хэрэглэн өмчид халдах тохиолдлууд гарлаа. Уул уурхай, мах бэлтгэх үйлдвэр зэрэгт хүч хэрэглэн халдах хэд хэдэн тохиолдол гарсан бөгөөд энэ хэргийг ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга удирдан хэрэгжүүлсэн нь бүр ч ноцтой зүйл юм. Цаашид төр эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж, хүний эрхийн зөрчил үйлдэх явдалд дасах вий гэсэн болгоомжлол төрүүлж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний тогтолцоо хангалттай бүрдээгүй байна. Иймээс дараах арга хэмжээг авах хэрэгтэй. Үүнд: а) Хүний эрх хамгаалагчдын үйлдлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хуулийн төслийг сайжруулан яаралтай батлах; б) Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг Парисын зарчимд нийцүүлэн өөрчлөн шинэчлэх ажлыг түргэсгэх; в) Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг сэргээн хэрэгжүүлэх;
2. Иргэний оролцооны эрхийг хангах олон хууль баталсан боловч энэ тухай иргэд мэдээлэлгүй, төрийн албан хаагчдын хэрэглэх чадавх сул байна. Иймээс эдгээр хуулийг олон нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдын чадавхыг сайжруулах сургалт тогтмол зохион байгуулах, зардлыг төсөвлөх үүнд иргэний нийгмийн байгууллагын чадавхийг дайчлахад анхаарч ажиллах;
3. Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дугаар заалтаар оруулсан өөрчлөлт болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хуульд 2019 оны 3 сарын 27-нд УИХ-аас оруулсан өөрчлөлтийг хүний эрхийн хэрэгжилтэд сөрөг үр дагавартай, улмаар нийгэмд үүссэн хардалт, зөрчлийг лавшруулах, шүүгч, прокурор, АТГ-ын хараат бус үйл ажиллагааг алдагдуулах уршигтай тул хянан цуцлах;
4. Нийтийн албанд хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэн авлига, хээл хахуулийн хэрэгт орооцолдох үзэгдэл түгээмэл байна. Энэ нь УИХ-ын гишүүдийн үйл ажиллагаа, улс төрийн нам, сонгуулийн тогтолцооны гажуудалтай холбоотой. Үүнийг засахын тулд а) УИХ-ын гишүүдэд хариуцлага хүлээлгэдэг, ёс зүй, зарчмаа зөрчсөн тохиолдолд эгүүлэн татдаг зохицуулалттай болох; б) Улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, намуудын хөгжлийн бодлого боловсруулан тууштай хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлэх; в) Иргэдийн санал худалдан авах, гарын бэлэг тараахын эсрэг арга хэмжээ авч сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Сонгуулийн Ерөнхий Хорооны ажлыг дэмжих, сонгуулийн сурталчилгааны үргүй зардлыг бууруулах, сонгогчдын улс төрийн боловсролыг сайжруулж намуудыг бодлого, хэрэгжилтээр нь сонгодог болох зэрэг эрхзүйн зохицуулалтуудыг гаргах;
5. Татвар, мэргэжлийн хяналт, шүүх, прокурорын байгууллагууд хуулиа хэрэгжүүлж, үүргээ биелүүлж чадахгүй байгаагаас төр тусгай ажиллагаа явуулж өөрөөр хэлбэл эрх мэдлээ хэтрүүлэн, хүч хэрэглэн асуудлыг шийдвэрлэх тохиолдол Салхитын орд болон мах бэлтгэн нийлүүлэх компанийн агуулахад гарсан нь харамсалтай. Энэ байдлыг давтаж болохгүйг анхаарч хуулиа хэрэгжүүлж чадахгүй байгаа явдалд дүгнэлт хийж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR II циклээс хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-тэй шууд холбоотой 8 зөвлөмж хүлээн авсан. Эдгээр зөвлөмжийн хэрэгжилтэд Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын зүгээс товч дүгнэлт тайланг бэлтгэн танилцуулж байна.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүний болон бусад нөөцийг хангалттай бүрдүүлэх шаардлагатай байна: ХЗДХ-ийн Сайдын ахалсан “Хүн худалдаалахтай тэмцэх” Дэд зөвлөл нь асуудал хариуцсан орон тооны бус нэг л мэргэжилтэнтэй ажиллаж байна. Цагдаагийн байгууллагад “хүн худалдаалах, түүх соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх” тасаг нь нэг дарга, дөрвөн мөрдөгчтэйгөөр зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бүх талуудыг чадавхжуулах шаардлагатай байна: Алба хаагчдыг мэргэшүүлэн сургах үйл ажиллагааны дийлэнх хувийг олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа дуусахад төрийн байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэн сургах үйл ажиллагаа зогсох дүр зураг харагдаж байна. Төрийн болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын давтан сургалтын хөтөлбөрт ороогүй, төрөөс жил бүр энэ сургалтыг давтамжтай явуулахад зардал төсөвлөдөггүй.

Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, буруутай этгээдэд ял оногдуулах шаардлагатай: 2015 онд баталсан шинэ Эрүүгийн хууль тогтоомжтой бүрэн танилцаж амжаагүй гэх шалтгаанаар прокурорууд 26 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон ноцтой асуудал гаргасан ба эрх мэдэл бүхий төрийн алба хаагч нар хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн тоог бууруулах зогсохгүй, гэмт хэрэгтэнд ямар ч ял шийтгэл оногдуулаагүй талаар олон улсын тайлан илтгэлд дурджээ.

КЕЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Хүний нөөц хангалтгүйгээс хөдөө, орон нутгаас хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж байсан тохиолдол жилд нийт илрүүлсэн тохиолдлын 4-5 хувиас хэтрэхгүй байна.

Өнөөг хүртэл хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх алба хаагчдыг чадавхжуулах үйл ажиллагаа төрийн бус болон олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр явагдаж байна. Тухайлбал, ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хүрээнд 2018 онд 2 удаагийн сургалтыг Хүйсийн тэгш эрх төв (ХТЭТ) зохион байгуулжээ. Мөн Азийн сангийн дэмжлэгтэйгээр шүүгч, прокурор, цагдаагийн байгууллага, хил хамгаалах, гадаадын харьяатын нийт 709 алба хаагчийг “ХХГХ-ийг хохирогч төвтэй аргачлалаар хянан шийдвэрлэх” сэдэвт сургалтад хамруулсан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хуулийн байгууллагын 2010-2016 оны статистик мэдээллээс үзэхэд хүн худалдаалах 8 гэмт хэрэгт 15 хүн, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 36 гэмт хэрэгт 54 хүн шүүхээс ял шийтгүүлсэн байна.

Хүүхэд худалдаалах бүхий л хэлбэрийг эрүүгийн хэрэгт тооцох: Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн асуудлаас гадна албадан хөдөлмөр, хөдөлмөр мөлжлөг, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр гэсэн ойлголт өнөөг хүртэл анхаарал татсан асуудал хэвээр л байна.

Хүүхдийг албан бус хэвшилд хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, хурдан морь унуулах, уран нугараачаар ажиллуулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, мал маллуулах, гуйлга гуйлгах зэрэг хөдөлмөр мөлжлөгийн хэргүүд бүртгэгдэж байгаа хэдий ч эцэслэн шийдвэрлэгдэхгүй, хүн худалдаалах гэмт хэргийн нэг төрөл гэдгээр зүйлчлэн ял шийтгэл оногдуулахгүй байна.

Хохирогчид үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх, хохирогч, гэрчид эрх зүйн туслалцаа, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх төсвийг бүрдүүлэх асуудал чухал байна: Улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдын аюулгүй байдлыг хангах зорилго бүхий хоёр төрлийн хамгаалах байрыг Хүйсийн тэгш эрх төв нь 2010 оноос эхлэн өнөөг хүртэл ажиллуулсан ба Засгийн газраас ямар нэгэн санхүүгийн дэмжлэг сүүлийн 5 жилийн хугацаанд аваагүй.

ХТЭТ нь 2019 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ХХГХ-ийн хохирогч хамгааллын асуудлаар нэг жилийн хугацаатай 20,000,000 (7,540 US\$) төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан хэдий ч энэ нь зөвхөн 15 хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах зардал юм. Харин хамгаалах байрны урсгал зардал, хүний нөөц зэрэгтэй холбоотой санхүүгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай: Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид нөхөн төлбөр, олговор олгох асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

2015 оны шинэ Эрүүгийн хуулийг батлахдаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад Эрүүгийн хуулийн 13.1 буюу хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод нөхөн олговор олгох асуудлыг хасаж, хүчингүй болгосон нь хохирогч хамгаалал, тэр дундаа нөхөн олговор олгох асуудалд ухралт болсон.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх “Дэд зөвлөл”-ийн үйл ажиллагааг өргөтгөж, байнгын үйл ажиллагаатай бүтэц бий болгох, салбар дундын зохицуулалтыг хангах зорилгоор үйл ажиллагааг нь эрчимжүүлэх;
2. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажилтнуудыг тогтмол мэргэшүүлэн сургах сургалтын тогтолцоог бий болгох, алба хаагчдыг хүн худалдаалах гэмт хэргийн бусад төрөл, хэлбэрүүдийг таньж мэдэхэд мэргэшүүлэн сургах боломжийг бүрдүүлэх, бэхжүүлэх;
3. Хөдөлмөр мөлжлөг, хилээр гарч буй жирэмсэн эмэгтэйчүүдэд хяналт тавих, уул уурхай дагасан бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг илрүүлэхэд анхаарал хандуулах;
4. Гэмт хэрэгтнүүдэд оногдуулж буй ял шийтгэлийг оновчтой, ял завшуулахгүй байхад анхаарах;
5. Хохирогчид нөхөн олговор олгох асуудлаар МУ-д хэрэгжиж буй хуулиудад үнэлгээ хийн, хуулийн хийдэл, давхардлыг илрүүлэх, хохирогчид учирсан нөхөн төлбөр олгох нөхцөлийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид оруулах;
6. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод шууд туслалцаа үзүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээний тогтолцоог бий болгох, үйлчилгээтэй холбогдон гарах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;
7. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд Хүн худалдаалах /13.1/ зүйл заалтыг дахин тусгах.



ЭРҮҮДЭН
ШҮҮХ
ЭСГҮЙ

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХҮНЛЭГ БУС ХАРЬЦААНААС АНГИД БАЙХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR II циклээс эрүүдэн шүүх, бусад хүнлэг бус харьцаанаас ангид байх хүрээнд нийт 20 зөвлөмж хүлээж авснаас ЭШЭК-ийн хувь хүний, улс хоорондын гомдол мэдээллийн журмыг хүлээн зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлэх амлалтаа биелүүлэх тодорхой алхам хийгээгүй байна. Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хүрээнд 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд “Эрүүдэн шүүх” үйлдлийг ЭШЭК-ийн 1-р зүйлийн тодорхойлолтод нийцүүлэн томъёолсныг иргэний нийгмийн байгууллагууд сайшаан дэмжсэн ч хүлээлгэх ял шийтгэл нь тус гэмт хэргийн “онц хүнд” шинжид бүрэн нийцээгүй, мөн “эрүүдэн шүүх” үйлдлийг өөр 4 төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд оруулсан нь гэмт хэргийн зүйлчлэлд тодорхойгүй байдлыг үүсгэхээр байгаад шүүмжлэлтэй хандаж байна.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Эрүүдэн шүүх гэмт хэргийн онц хүнд шинжид тохирох ял шийтгэл ногдуулаагүй, харин хүндрүүлэх шинжийг өөр 4 төрлийн гэмт хэрэгт заасан нь зүйлчлэлийн хувьд тодорхойгүй байдал үүсгэхээр байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “бусад хүнлэг бус харьцаа”-г хориглосон ч энэ үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй.

Эрүүдэн шүүгдсэний улмаас үүсэх сэтгэл санааны хохирлыг барагдуулах асуудлыг тодорхой зохицуулаагүй.

Эрүүдэн шүүсэн тохиолдлыг хараат бусаар мөрдөн шалгах албыг 2014 оны 1-р сард татан буулгаснаас хойш эрүүдэн шүүсэн тохиолдлыг хараат бусаар мөрдөн шалгах байдал хангалтгүй байгааг ХЭҮК-ын тайлангуудад тодорхой дурдагдаж байна. Энэ нь буруутай этгээдэд ял завших боломжийг олгож байна.

Монгол Улс 2014 оны 12 дугаар сарын 11-нд ЭШЭК-ийн Нэмэлт протоколыг соёрхон баталсан ч Урьдчилсан сэргийлэх үндэсний механизм байгуулах үүргээ өнөөг хүртэл биелүүлээгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг дангаараа гэм буруутайг тогтоох шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байх зарчмыг тусгасан нь тун чухал алхам хэдий ч эрүүдэн шүүж олж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байхаар хатуу зохицуулаагүй.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

“Эрүүдэн шүүх” гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 21.12-р зүйлийн дагуу 5,4-27 сая төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жилийн хорих ял ногдуулна.

Шүүх зөвхөн бодит хохирлыг нөхөн төлдөг практик тогтоод байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээгээр 2017, 2018 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хянан шийдвэрлээгүй байна. Гэвч ХЗДХ-ийн Сайд Ц.Нямдорж хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монгол Улсад эрүүдэн шүүлт бодитой явагдсан гэдгийг албан ёсоор хүлээгээд байгаа билээ.

Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг Протокол хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор буюу 2016 оны 2-р сарын 12-ны дотор байгуулах үүрэг хүлээсэн байсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.12 дугаар зүйлд эрүүдэн шүүх замаар олж авсан нотлох баримтыг 16.11-ийг баримтлан нотлох баримтаар тооцохгүй гэсэн ч тус 16.11-р зүйлээр нотлох баримтаар тооцох эсэхийг шүүх шийдвэрлэхээр заасан тул ЭШЭК-ийн зарчимтай бүрэн нийцэхгүй байна.

Манай улсын тухайд эрүүдэн шүүх асуудлаар хуульч, хууль сахиулагчдыг сургах алхмууд авч хэрэгжүүлдэг ч бусад мэргэжилтэн, тухайлбал, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, асрамж, халамжийн газрын ажилтнууд, цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдад энэ чиглэлийн сургалт зохион байгуулах ажил сул байна.

Цэргийн анги нэгтгэл дээр цэрэг амь насаа алдах, эд эрхтнээрээ хохирох хэрэг удаа дараа гарсан.

Мөрдөн шалгах нууц ажиллагааны зөвшөөрлийг шүүх биш прокурор өгч байгаа нь учир дутагдалтай. Мөн цагдан хорих байранд “мөрдөн шалгах нууц ажиллагаа” явуулахыг бүрмөсөн хориглохгүй бол эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд тодорхой ахиц гарахгүй.

ХЗДХ-ийн Сайд Ц.Нямдоржийн нийтэд зарласан эрүүдэн шүүсэн хэрэг нь цагдан хорих байранд хийгдсэн гүйцэтгэх ажлын бичлэг юм.

Цагдан хорих нийтлэг журам үйлчилж байгаа болон цагдан хорихоос өөр таслан сэргийлэх арга хэмжээний хувилбар байхгүй хэвээр байна.

Сүүлийн үед авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдуулан хүнийг шалгахдаа заавал цагдан хорих ёстой мэтээр олон нийтийг турхирах, таслан сэргийлэх арга хэмжээ авах хүсэлт гаргаагүй прокурорыг буруутгах, шийдвэр гаргах шүүгчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нөлөөлөх оролдлого ихээр гарч байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. ЭШЭК-ийн хувь хүний, улс хоорондын гомдол мэдээллийн журмыг хүлээн зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлэх;
2. Хараат бус мөрдөн шалгах албыг НҮБ-ын бүх шаардлагад нийцүүлэн нэн даруй байгуулах, ингэхдээ тусгай субъектийн үйлдсэн бүх хэргийг бус зөвхөн эрүүдэн шүүх, зүй бус харьцаатай холбоотой мөрдөн шалгах эрхийг олгох замаар дагнасан, мэргэшсэн, цомхон байх боломжийг хангах;
3. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг ЭШЭК-ийн Нэмэлт протоколд бүрэн нийцүүлж, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангасан, хараат бусаар ажиллах, чиг үүргээ хэрэгжүүлэх хангалттай эрх хэмжээтэй, гаргасан шийдвэр, зөвлөмж нь хэрэгждэг байхаар зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах;
4. Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр зүйлд буй “эрүүдэн шүүх” үйлдлийг нэгтгэн, нэг гэмт хэрэг болгон тодорхойлж, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх” үйлдлийг гэмт хэрэгт тооцож, шинээр зүйлчлэх;
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүдэн шүүж олсон нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх, хууль бус тушаал, даалгавар биелүүлсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй байх талаар холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, цагдан хорих байранд “гүйцэтгэх ажил” явуулахыг хориглох, мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг “шүүх” олгодог байх, зөвшөөрлийн хүрээ, хязгаарыг журмаар биш, хуулиар нарийвчлан зохицуулах;
6. Хохирол барагдуулах үндэсний тогтолцоог нэн даруй бий болгох, эдийн бус хохирлыг үнэлэх, тооцох аргачлалыг нэн даруй батлан гаргах, үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагуудад эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх мэргэшсэн чиг үүрэг бүхий шинжээч эсхүл энэ чиглэлийн албыг байгуулж, ажилтнуудыг мэргэшүүлэн ажиллуулах замаар хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
7. Сургалтын хөтөлбөрийг Истанбулын протоколд нийцүүлэн боловсруулах, хуульч, хууль сахиулагчдаас гадна эмнэлгийн мэргэжилтэн, бусад холбогдох ажилтнуудыг сургахад анхаарах, мөн сургалтын чанарт хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх.



ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR II циклээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээнд 8 зөвлөмж хүлээж авсан ч хэрэгжүүлээгүй байна. Үүнд, Харилцаа холбооны зохицуулах хорооны бие даасан байдлыг хангах, нэр төр гутаах гэмт хэргийг халах, цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хязгаарлалтыг хууль ёсны, зайлшгүй, хэм хэмжээндээ байх зарчимд нийцүүлэх, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон шүгэл үлээгчийг хамгаалах, сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллага өөрсдийн үйл ажиллагааг аливаа айдасгүйгээр чөлөөтэй эрхлэх боломжоор хангах, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжлах, шүүмжилсний төлөв мөрдөн хавчигдах, эсхүл дарамт шахалтад орохоос хамгаалах орчныг бүрдүүлэх зэрэг зөвлөмж багтсан болно.

ШИНЭЭР ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Монгол Улс өгөгдөл хамгаалах хууль тогтоомжгүй бөгөөд 1995 оны Хувь хүний нууцын тухай хуульд энэ зохицуулалт байхгүй болно.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

- Хязгаарлах мэдээллийн хүрээ хэтэрхий өргөн;
- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй бие даасан байгууллага байхгүй;
- Төрийн байгууллагууд мэдээллийн ажилтангүй.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Хувийн компани, банкууд үйлчилгээндээ хүний хурууны хээ ашиглаж эхэлсэн. Монголын томоохон сүлжээ дэлгүүрийн нэг “Номин” хөнгөлөлтийн карт эзэмшигчдэдээ хурууны хээгээ ашиглахыг санал болгож байна.

Глоб Интернэшнл төвөөс хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний хүрээнд төрийн 16 байгууллагаас мэдээлэл хүссэн боловч зөвхөн 5 байгууллага бүрэн гүйцэд хариулт өгсөн.

УБ хотын иргэн Дархан-Уул аймгийн ЗДТГ-т хандан агаар, хөрсний бохирдлыг хэмжих төхөөрөмж худалдан авах ажиллагаатай холбоотой тендер, сонгон шалгаруулалт, гэрээний мэдээлэлтэй танилцах хүсэлт илгээсэн ч хариу өгөх дээд хугацаа болох 14 хоногт мэдээллийг өгөөгүй байна. Иргэн мэдээллээ авах хүсэлтээ утсаар сануулахад хуульд байхгүй шаардлага тавьж өөрийн биеэр ирэхийг хүссэн байна.

УИХ-аас 2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хууль баталсан. Шинэ хуулиар Засгийн газар Нууцын журам, Нууц мэдээллийн жагсаалтыг батлах бөгөөд үүний дагуу төрийн байгууллагууд дотооддоо нууцын журам, нууц мэдээллийн жагсаалтаа батлах болсон байна.

Үндсэн хуулиар задруулж үл болох нууцыг хуулиар тогтоон хамгаалах тухай заалттай байтал УИХ биш ЗГ тогтоож байгаа нь зөрчилдөж байгаа юм.

Өмнөх хуулиар 60 байсан нууц мэдээллийн тоо 2019 онд 565 болон нэмэгджээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.2 дугаар зүйлээр харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох нөхцөлийг тусгасан. Энэ заалтаар мөрдөгч нь дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулж авахдаа шүүхийн шийдвэрээр бус зөвхөн прокурорын зөвшөөрлөөр авах боломжтой болжээ.

Тус заалтаар харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх, хяналт тогтоох зүйл багтсан.

УИХ 2015 оны Сонгуулийн тухай хуулийг хүчингүй болгож, Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай гурван тусдаа хууль батлахаар төлөвлөж, төслүүд нь бэлэн болоод байна. Хуулийн төслүүдэд хэвлэл мэдээлэлд ногдуулах шийтгэлийг чангаруулахаар яригдаж байна.

Санал хураах өдөр хүртэл үйл ажиллагааг зогсоох, өргөн нэвтрүүлгийн лицензийг цуцлах, хүчингүй болгох, цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг хаах зэрэг хатуу зохицуулалтууд тусгахаар яригдаж байна.

цахим орон зай, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараахыг хориглоно.

2018 оны УИХ-ын сонгуулийн үеэр 11 мэдээ, мэдээллийн цахим хуудсыг хаасан.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн дагуу олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх үүрэгтэй тул Монгол Улсын Засгийн газар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах, хамгаалахаар хүлээн авсан Зөвлөмжөө хэрэгжүүлэх хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнээс гадна, дор дурдсан шинэ зөвлөмжүүдийг санал болгож байна.

1. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх заалтыг хүчингүй болгох;
2. Олон нийтийн зүтгэлтнүүд нээлттэй шүүмжлэлд хүлээцтэй хандах, олон нийтийн хараа хяналтад байхаар өөрсдөө сонголт хийснийг хүлээн зөвшөөрсөн хууль тогтоомж санаачлах;
3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд хязгаарлалтын хүрээг нарийвчлах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бие даасан байгууллага томилох чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах;

4. Төрийн болон албаны нууцын тухай хуульд хязгаарлалтыг Засгийн газрын тогтоол, төрийн байгууллагын дотоод журмаар бус, гагцхүү хуулиар тогтоохоор өөрчлөн батлах. Ингэхдээ хууль ёсны байх, зайлшгүй байх, хэмжээндээ байх гурван талт шалгуурт тулгуурлах. Нууцын бүх хууль ноцтой хор хохирол учруулах шалгуурт нийцэх, түүнчлэн энэхүү хор хохирол нь олон нийтийн ашиг сонирхлоос илүү чухал байх нөхцөлийг хангасан байх;
5. Эрүүгийн хуулийн “Төрийн нууц мэдээллийг хууль бусаар олж авах” хэмээх 19.11 дэх зүйл хэсгийг өөрчлөх;
6. Өгөгдөл хамгаалах хууль тогтоомж батлах;
7. Сонгуулийн гурван хуулийн төсөлд одоогоор тусгагдсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой заалтуудыг олон улсын хэмжээнд нийцүүлэн өөрчлөх, өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах заалтуудыг хүчингүй болгох.



БҮЛГИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ МОНГОЛД

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR II циклээс эмэгтэйчүүдийн эрхийн хүрээнд 39, хүүхдийн эрхийн хүрээнд 45, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хүрээнд 10, ахмад настны эрхийн хүрээнд тус бүр 4 зөвлөмж хүлээж авсан бөгөөд хэрэгжүүлэх хүрээнд шинэ хууль тогтоомж баталсан, тогтолцоог бэхжүүлэх алхмуудыг хийж эхэлснийг иргэний нийгмийн байгууллагууд сайшаан тэмдэглэхийн зэрэгцээ эдгээр бүлгийн эрхийн хүрээнд тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжийг танилцуулж байна.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Хүүхдийн эрхийг хангах салбар дундын бодлого зохицуулалт сул байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог бий болгосон ч мэдээллийн уялдаа холбоогүйгээс өсвөр насныханд хамгааллын үйлчилгээг хүргэж чадахгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 20-р зүйл, Хүүхэд хамгааллын хуулийн 15-р зүйлийн нийцэл сулаас нийгмийн бүхий л орчинд үүссэн асуудлаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. Эрүү, зөрчлийн процессын хуульд хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой зохицуулалт байхгүй байна.

Ажлын байрны бэлгийн дарамт (АББД)-д өртсөн хохирогчдын 98 хувь, ажлын байрны дарамтад өртсөн хохирогчдын 79 хувь нь эмэгтэйчүүд байна. Ижил үнэлгээтэй ажилд ижил цалин хөлс авах зарчим хэрэгжихгүй, цалингийн дунджийн ялгаатай байдал санхүүгээс бусад салбарт нэмэгдэж байна. Эмэгтэйчүүд бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настныг асарч үйлчилдэг гэсэн шалтгаанаар эдийн засгийн идэвхгүй болж байна. Охид, эмэгтэйчүүд тэр дундаа малчин эмэгтэйчүүд хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж, хамгийн бага үнэлгээтэй эсхүл үнэлгээгүй хөдөлмөрт цаг заваа зарцуулж байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонгох, сонгогдох тэгш эрх хангагдахгүй байна. Сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчдийн 30 хувийг аль нэг хүйсийн төлөөлөл байх заалтыг сонгууль болохоос сар хүрэхгүй хугацааны өмнө 20 хувь болгож бууруулсан. Намдаа өгөх мөнгөн хандивын хэмжээгээр нэр дэвшигчдийг шалгаруулдаг тул эмэгтэйчүүд энэхүү мөнгөний босгыг давахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

- Хүүхдийн эрхийг хангах, салбар дундын зохицуулалтыг дэмжих эрх зүйн орчныг салбаруудын оролцоотой үнэлж, зохих хууль тогтоомжийг шинэчлэх;
 - Эрүүгийн процесст оролцогч хүүхэд, өсвөр насныханд хамгааллын үйлчилгээ үзүүлэх боломжийг шаардлагатай хууль тогтоомжид нэмж тусгах;
 - Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудад нийтлэг зарчмын дагуу мониторинг хийж, салбар дундын зохицуулалтыг сайжруулах.
-
- Хөдөлмөрийн тухай хуулийг хөдөлмөрлөх эрхийг дордуулахгүйгээр батлах, батлагдсан хуулийг олон нийтэд сурталчлан таниулах;
 - Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр нийт төрийн албан хаагчийг чадавхжуулах;
 - Хөдөлмөрлөх эрхийг хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин бүрдүүлэхэд тусгай арга хэмжээ авах;
 - Ажлын байрны бэлгийн дарамтыг гэмт хэрэгт тооцох, урьдчилан сэргийлэх;
 - Улс төрийн шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангаагүй улс төрийн намын сонгуульд оролцох эрхийг хязгаарлах хариуцлагыг хуульд тусгах.

Тэтгэвэр нь амьжиргаанд хүрэлцдэггүй, өөр цаг хугацаанд адил хөдөлмөр эрхэлж байсан хүмүүсийн тэтгэврийн зөрүү их байгаа зэрэг нь тулгамдсан асуудал юм. Тухайлбал, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан ахмадуудын дундаж тэтгэвэр 322,671 (121 ам.доллар) байгаа бол 1995 оноос хойш тэтгэвэрт гарсан ахмадуудын дундаж тэтгэвэр 716,123 (268 ам.доллар) төгрөг байна. Энэ нь амьдралын тодорхой хугацааг социалист нийгэмд өнгөрүүлсэн ахмад настнуудын эрх ашиг хохирч байгааг харуулна. 2019 оны 7-р сарын байдлаар 310000 (116 ам.доллар) хүртэлх тэтгэвэр авч буй ахмадууд 44.9 хувь (127,099 хүн), 310001-600000 (116-225 ам.доллар) төгрөгний тэтгэвэр авдаг ахмад 46.1 хувь (130,545 хүн), 600001- 1920000 (225-720 ам.доллар) хүртэл тэтгэвэр авч буй ахмад нийт тэтгэвэр авагчдын дөнгөж 9 хувь (25,670 хүн) байна. Ахмад настнуудын 91 хувь бага тэтгэвэртэй байгаа нь тэдний амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

- Өөр цаг хугацаанд адил хөдөлмөр эрхэлж байсан ахмад настны тэтгэврийн зөрүүг арилгах замаар тэгш бус байдалд өртөж хохирсон бүлгүүдийн эрхийг сэргээх;
- Ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр амжилттай хэрэгжиж байгаа нийгмийн халамжийн хөтөлбөрүүдээ цаашид үргэлжлүүлэх;
- Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн цогц тогтолцоог бүрдүүлж, асаргааны даатгалын эрх зүйн орчин бий болгох, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийг 2016 онд баталсан ч салбарын хуулиудад дагаж орох нэмэлт, өөрчлөлт өнөөг хүртэл гараагүй. Энэ нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Сүүлийн хоёр жилийн улсын төсөвт тэгш хамруулах боловсролд мөнгө зарцуулаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэхээр заасан. ХБХЭК дахь хүртээмж, тохирох хэрэглэгдэхүүн, дэмжлэг гэсэн ойлголтууд хоорондоо давхцсан, хэрхэн ялгамжтай хэрэглэх нь тодорхойгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “бие даан амьдрах эрх”-ийг тусгасан ч бие даан амьдрах үйлчилгээний санхүүжилтийг хуульд тусгаагүй тул хэрэгжихгүй байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуультай салбарын бусад хуулийг нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр санхүүжилт, төсвийн хэмжээг тогтмол нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах эрхийн хэрэгжилтийг хангахын тулд санхүүжилтийг үр дүнтэй, хүрэлцээтэй байдлаар шийдэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үл тоомсорлох, ялгаварлан гадуурхах уламжлалт хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажлыг нэн тэргүүнд төрийн бүх шатны алба хаагчдад чиглүүлэн зохион байгуулах.



ХҮНИЙ ЭРХИЙГ
ХУУЛИАР
ХАМГААЛДАГ

Улаанбаатар, 2019 оны 10 сарын 14

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ

Цагдаагийн байгууллагад сүүлийн 3 жилд 947 буюу ойролцоогоор өдөрт нэг бэлгийн хүчирхийлэл бүртгэгдэж шалгагдсан. Хохирогчдын 80 хувь орчим нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд, 46.8 хувь нь 8-17 насны охид байна. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 30 хувиар өссөн тухай албаны статистик байгаа ч ихэнх тохиолдолд хохирогчид хуулийн байгууллагад хандахгүй өнгөрөөх, хандсан ч хэрэгсэхгүй болгох, өргөдлөө татаж авах, тохиролцох зэргээр асуудал орхигдож байгаа тул НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR III циклд энэ асуудлаар тусдаа тайлан бичсэн болно.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Насанд хүрээгүй, бага насны хүүхэд ялангуяа охидын эсрэг хүчингийн гэмт хэрэг үүнд, ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа ч энэ төрлийн гэмт хэрэгт өртөж буй бага насны хүүхэд, ялангуяа охидын эрхийг хамгаалах эрх зүйн орчин дутмаг байна. Ураг төрлийн болон таньдаг хүндээ хүчиндүүлсэн тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлдэггүй, мэдээлсэн ч томчууд хоорондоо “тохиролцоод” хүүхэд хохироод үлддэг асуудал оршсоор байгаа нь хохирогчийн эрх ашгийг бүрэн төлөөлж чадаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байгааг УЕПГ-ын 2019 оны судалгааны үр дүн харуулсан.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин дутмаг байна. Шинэ Эрүүгийн хуулиар “18 насанд хүрсэн хүн хохирогчийг 14 насанд хүрсэн 16 насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон” тохиолдолд хүлээлгэх торгуулийн хариуцлагыг 5-22 дахин бууруулсан. Мөн өмнөх зохицуулалтаар хүчингийн гэмт хэргийн хүндрүүлэх шалтгаанаар тооцдог байсан хохирогчийг жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол зургаан сараас гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь хүүхдийн бэлгийн эрх чөлөөг хамгаалахад ухралт болсон.

Шинэ Эрүүгийн хуульд заасан “Бэлгийн дарамт учруулах” гэмт хэргийг 2017 оны хуулиар хүчингүй болгосон нь ухралт болсон.

КЕЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Цагдаагийн байгууллагад шалгагдсан хэргийн 45.2 хувь нь л шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тоо мэдээгээр “бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн улмаас тус хүрээлэнгээр шинжилгээ хийлгэгчдийн 45.6 хувь буюу 881 нь 0-19 хүртэлх насны хүүхдүүд байна.

Шинэ Эрүүгийн хуулийн уршгаар 14-16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2018 оны эхний 10 сарын байдлаар өмнөх оноос 70 хувиар өссөн. Тухайлбал, Өмнөговь аймгийн шүүхээс “26 настай А нь 14 настай Ц-г арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдсээр байж бэлгийн харьцаанд орж, хохирогчийг жирэмсэн болгосон, 5 сартай үр зулбасан” гэх үндэслэлээр 8 сарын хугацаагаар хорих ял оногдуулсан байна.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн шүүхээр хэргээ шийдүүлэх явцад хувийн нууцтай байх, хамгаалагдах зэрэг эрхүүд зөрчигдөж байна. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдыг нөхөн сэргээх, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ байхгүйгээс бүх байгууллагаар өөрөө явж үйлчилгээ авах болдог нь эдийн засаг, цаг хугацаа, сэтгэл санааны хувьд давхар хохирлыг учруулж байна. Монгол Улсад мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн дутмаг, мэргэжилтнүүд trauma-informed system/care талаар ойлголцогүй байна.

5 настай хүчингийн хэргийн хохирогч охин шинжилгээний төлбөрт өгөх 10,000 төгрөг байхгүйгээс үзлэгт орж чадахгүй байсан тухай нийгмийн сүлжээгээр хурдацтай тархаж, үүний дараа ХЗДХЯ-аас 0-18 насны хохирогчийг төлбөрөөс чөлөөлөхөөр шийдвэрлэсэн байна. Харин 18-аас дээш насны хохирогч төлбөрийн чадваргүй бол заавал оршин суугаа газраасаа тодорхойлолт авахаар зохицуулсан нь хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах үндсэн зарчимтай зөрчилдөж байна.

Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдод учирсан хор хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцох, сэтгэл санааны хохирол болон нөхөн сэргээх зардлыг тооцож олгодоггүйгээс зөвхөн эрүүл мэндийг нөхөн сэргээхэд зарцуулсан баримтад тулгуурлан хохирлыг шүүх тогтоож байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. 2015 оны Эрүүгийн хуулийн 12.5-р заалтыг өөрчлөн найруулах;
2. “Бэлгийн дарамт учруулах” үйлдлийг гэмт хэрэгт тооцож сэргээх;
3. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийг шалгах, шийдвэрлэх стандарт батлах;
4. Хүчиндэх гэмт хэргийн материаллаг бус хохирлыг тооцдог болон сэтгэл засал, нөхөн сэргээх эмчилгээний зардлыг буруутай этгээдээс гаргуулдаг эрх зүйн механизмыг бий болгох;
5. Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэл зүйд учирсан гэмтлийг тогтоох, сэтгэл санааны хохирлыг үнэлэх, тооцох аргачлалыг батлах, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн тодорхой зохицуулалт, механизмыг бүрдүүлэх;
6. Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг сэтгэл санааны давхар дарамтад оруулахаас сэргийлэх үүднээс хохирогчтой ажиллах арга, тусламж үйлчилгээний зөв дараалал, жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, хохирогчийн эрх, хүчирхийллийн шинж тэмдгүүдийг таних зэрэг асуудлаар эмч, багш зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын модуль боловсруулж, тасралтгүй зохион байгуулах;
7. Шүүх шинжилгээний байгууллагад хандаж буй бэлгийн хүчирхийллийн бүх насны хохирогчдыг үнэ төлбөргүй шинжилгээнд хамруулж байх, тоо мэдээ гаргах аргачлалыг сайжруулах, боловсронгуй болгох, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад статистик мэдээллийг нээлттэй болгох, шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангах;
8. Хохирогч буруутгах хандлага хийгээд бэлгийн хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдлэг, мэдээлэл түгээх ажиллагааны бүхий л үйд явцад хүүхдийн (охид, хөвгүүд) оролцоог бүхий л түвшинд ханган албан болон албан бус аргаар орон даяар нэвтрүүлэх;
9. Охид хөвгүүдийн бэлгийн боловсролыг нэмэгдүүлэх;
10. ЕБС-ийн охидын үзлэг нэрээр охидын нэр хүнд, аюулгүй байдалд бүдүүлгээр халдаж байгааг халах.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR II циклээс эрүүл мэндийн суурь үйлчилгээг хүргэх тогтолцоотой холбоотой 5 зөвлөмж хүлээж авснаас эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр санаачилга гарган ажиллаж байгаа ч эрүүл мэндийн суурь үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний хамрах хүрээ, хүртээмжийг өсгөн нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх хүрээнд хангалттай алхам хийгдээгүй байна.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэдийн хувиасаа төлөх төлбөр өсч, ядууралд хүргэж байна. Хувь хүний халааснаасаа гаргах эрүүл мэндийн санхүүжилтийн хэмжээ 25 хувиас хэтэрвэл ядуурал гүнзгийрч, орлогоос хамааралтай тэгш бус байдал өснө гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага үздэг.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс хуваарилах санхүүжилт болон ЭМДС-д төрөөс хариуцан төлөх шимтгэл аль аль нь хэт бага байна.

Монгол Улс хавдрын улмаас нас барагсдынхаа тоогоор дэлхийд тэргүүлж байгаа ба агаарын бохирдол нэмэлт сорилт авчирч, эрүүл мэндийн төсвийн ачаалал өсөж байна.

Эрүүл мэндийн даатгалын сан эрүүл мэндэд учрах эрсдэлийг хааж чадахгүй байна. Хорт хавдрын химийн эмчилгээ, хорт хавдрын өдрийн туяа эмчилгээ, өндөр үнэтэй эм, хэрэгсэл тодорхой хэмжээгээр даатгалд багтах болсон ч улсын эмнэлгийн ачааллаас шалтгаалан яаралтай тохиолдолд энэ боломжийг иргэд эдэлж чадахгүй байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Эрүүл мэндийн санхүүжилтийн 40 хувийг улсын төсвөөс, 20 хувийг Эрүүл мэндийн даатгалын сан (ЭМДС)-аас, үлдсэн 40 хүртэлх хувийг иргэд хувиасаа гаргаж байна.

ДНБ-ий 2.6 хувийг л эрүүл мэндийн салбарт хуваарилж байна. Нийт даатгуулагчдын 58.2 хувийг төрөөс хариуцаж сангийн нийт орлогын 11.2 хувийг, ажил эрхлэгчид нийт даатгуулагчдын 25.7 хувийг эзэлж, сангийн нийт орлогын 80.5 хувийг бүрдүүлж байна.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2018 оны судалгаа, тооцооллоос үзэхэд агаарын бохирдлыг бууруулахгүй бол хүүхдийн өвчлөлийг анагаах зардал жил бүр 5 тэрбум (1,877,582\$) төгрөгөөр нэмэгдэх төлөвтэй байна.

Гэтэл Эрүүл мэндийн даатгал жил бүр 200 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гардаг бөгөөд үүний шалтгаан нь Сангийн яам тус сангийн мөнгийг банкинд хадгалуулж, хүүгээр нь орлого бүрдүүлэхийг шахдаг ажээ. Учир нь төр өөрийн хариуцах даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг хүүгийн орлогоор бүрдүүлдэг байна. 2020 онд төр 122 тэрбумыг өгөх ёстой ч 84 тэрбум олгохоор төсөвтөө тусгасан байна.

ЭМДС-ийн мөнгийг үрэлгэн, оновчгүй зарцуулж байна. Эрүүл мэндийн даатгал нь даатгуулагчид эрүүл мэндийн эрсдэл учирсан үед санхүүгийн эрсдэлээс хамгаалах үүрэгтэй, гэтэл угаасаа хүрэлцдэггүй, эрсдэлийг хаах чадамжгүй байхад фитнес, иог, спорт клубт зарцуулах шийдвэр гаргасан нь даатгалын үндсэн зарчмаас зөрж байна.

2019 оны 1-р сараас эхлэн фитнес, иог, спорт клубт хичээллэж байгаа 8,3-33,3 мянган даатгуулагчийн зардлыг ЭМДС-аас хариуцахаар 2 тэрбум (751.033\$) төгрөг төсөвлөжээ.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хараат болж, даатгуулагчдын оролцоо, хяналт бага байна. Ажил олгогч, даатгуулагчийн төлөөллийн оролцоог хангасан гэж үзэж байгаа ч нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, энэ үйл явц нээлттэй байх асуудлыг орхигдуулсан.

Сангийн удирдах байгууллагыг Эрүүл мэндийн сайд удирдаж, даатгалын сангийн үйл ажиллагааг удирдах байгууллагын төсөв тус сайдын багцад байх бөгөөд даргыг сайд томилно.

БАРИМТ

ИРГЭН Ш-ИЙН ТҮҮХ

2018 оны 3 сараас 2019 оны 2 сарын 22 хүртэл хөхний хорт хавдрын эмчилгээ хийлгэж байгаа 38-58 насны 12 эмэгтэйг төлөөлж байна. Би анх Хавдар судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-д онош тодруулахаар очсон ч ачаалал ихээхэн 20-иод хоног хүлээх болсон тул аргагүйн эрхэнд Интермед хувийн эмнэлэгт үзүүлэн хагалгаанд орж, 8 удаагийн химийн эмчилгээ хийлгэн нийт 30 сая төгрөг (11,265.5\$) төлсөн. Үүнээс цааш ч үйлчилгээ авахаар очих бүрт сар гаруй хугацаанд хүлээх хэрэгтэй болж, цаг алдахгүйн үүднээс нэмэлт төлбөр байнга төлж байна. Эцэст нь хавдар дахих магадлал өндөр тул 21 хоногийн давтамжтай 2 тариаг жилийн хугацаанд хийлгэх болсон ч 4 сая төгрөгийн (1502\$) үнэтэй тариаг авах мөнгөгүйн улмаас 30 ширхэг нь 139 мянган төгрөгийн (52,2\$) үнэтэй гормоны эмийг 5 жил уухаас өөр аргагүй болсон. Миний сарын цалин 700,000 (263\$), сүүлийн 5 жилд би нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд 22 сая төгрөг (8,261\$) төлсөн ч бодит амьдралд уг даатгал миний эрүүл мэндэд учрах эрсдэлийг хааж чадаагүй.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. Даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа санхүүгийн эрсдэлд орохгүй байх үзэл баримтлалд суурилан Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах;
2. Даатгалд хүн амаа аль болох бүрэн хамруулах үүднээс эв нэгдлийн буюу тэгшитгэх зарчмаа хэвээр хадгалахын зэрэгцээ ажиллагч болон ажил олгогч хураамжийг тэгш хуваан хариуцах, хүүхэд, өндөр настан зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүн амын даатгалын хураамжийг төр хариуцаж байгаа зарчмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
3. Эрүүл мэндийн санхүүжилтийн бүтцийг оновчтой болгох: Үүнд: 1) Улсын төсөв дэх эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 5-6 хувь болгох замаар төрөөс даах тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх; 2) даатгуулагчдын 60 гаруй хувийг эзэлж байгаа тэтгэврийн насныхан болон хүүхдүүд, жирэмсэн эхчүүд, цэргийн албан хаагчид зэрэг иргэдийн төрөөс хариуцан төлж байгаа шимтгэлийн хэмжээг нэмэх, шимтгэлийн дунджид ойртуулах;
4. Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ худалдан авдаг, үйлчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч (сан), үйлчилгээ үзүүлэгч (ЭМЯ) хоёрыг тусгаарлаж, үйлчилгээ үзүүлэгчид хяналт тавих эрхийг даатгуулагчид өгөх;
6. Иргэдэд эрүүл мэндийн эрсдэл учирсан үед ашиглах нэмэлт сонголт бий болгох үүднээс хувийн даатгалыг хослуулан хөгжүүлэх эрх зүйн орчин, зохицуулалтыг бий болгох;
7. Даатгалын сангийн зарцуулалтыг ил тод болгох, иргэний нийгмийн хяналтын механизмыг бий болгон хөгжүүлэх;
8. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид бүтээгдэхүүнээ сонгож үйлчлүүлэх боломжийг нээлттэй болгон хуульчлах;
9. Даатгалаараа шаардлагатай бүх үйлчилгээ, эмчилгээгээ төвөг багатай авдаг систем бүрдүүлэх.

БОДЛОГЫН УЯЛДААГҮЙ ХӨГЖИЛ БА ХҮНИЙ ЭРХ



Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR II циклээс байгаль орчин ба нүүдэлч хүн ам, шилжин суурьшигчдын талаар 8 зөвлөмж хүлээж авсан ч хэрэгжилт хангалтгүй байна. Уул уурхайд түшиглэн үсрэнгүй хөгжих бодлого баримталж, хөрөнгө оруулалт татах зорилгоор хууль эрх зүй, татварын таатай орчин бүрдүүлж ирсэн ч байгаль орчин, хүнд нөлөөлөх байдлыг үнэлэх асуудлыг орхигдуулж ирсэн. Үүний зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх, байгаль экологи ба төрөл зүйлийг хамгаалах тухай 10 гаруй конвенц, дагалдах протоколд Монгол Улс нэгдэж, хэрэгжүүлэх үүрэг амлалтаа боловсруулсан. Гэвч НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс (UNECE)-оос хийсэн Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ (БОГУ)-нд “...хэдийгээр Монгол Улс ...байгаль хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлсэн ч хэрэгжилт нь хангалтгүй... Мөн Ногоон хөгжлийн бодлоготой боловч Стратегийн нөлөөллийн үнэлгээг (СНҮ) салбаруудын нөлөөллийг үнэлэхэд хэрэгжүүлээгүй байна” гэж дүгнэсэн.

БОДЛОГЫН УЯЛДААГҮЙ ХӨГЖЛИЙН УЛМААС ДАРААХ ЭРХҮҮД ЗӨРЧИГДӨЖ БАЙНА:

1. Хөгжих, Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын үр шимийг хүртэх эрх
2. Албадан нүүлгэлтээс хамгаалагдах, зохистой нөхөн олговор авах эрх
3. Газартай, орон гэртэй, амьжиргааны орлоготой байх эрх
4. Уламжлалт бэлчээрт нүүдэллэх эрх
5. Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх
6. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
7. Химийн болон бусад хорт хаягдлаас хамгаалагдах эрх
8. Чөлөөтэй зорчих, амьдрах газраа сонгох эрх

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

2012 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль хэрэгжихгүй байна. Ялангуяа уул уурхай, эрчим хүч, барилга, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулахдаа хүний амьдрах орчин, амьжиргааны хэрэглүүр болох бэлчээр ус, тариалан, суурьшлын бүсийн газарт лиценз олгосноор хөдөө аж ахуйн салбарууд шахагдаж, хот руу чиглэсэн дотоодын дүрвэгсдийн урсгал нэмэгдэж, орон байргүй амьжиргаагүй болсон өрх, хүмүүсийн тоо буурахгүй байна. Эрх нь зөрчигдсөн хүн ам, ялангуяа бэлчээрээ алдсан нүүдэлч хүн ам эрхээ сэргээлгэх, зохистой нөхөн олговор авах, албадан нүүлгэлтээс хамгаалагдах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

КЕЙС, ЖИШЭЭ, БАРИМТ

УБ хотын дэд бүтцийн даац хэтэрч агаар, орчны бохирдол гамшгийн хэмжээнд хүрээд байна. АХБ, ЕХОБ, Уур амьсгалын ногоон сан, ОУСК-ын хамтарсан зээлээр орон сууц, дэд бүтцээр хангах нь бохирдлын шийдэл хэмээх хөтөлбөр хэрэгжүүлж байна. Шинэ орон сууцыг дулаан, цахилгаанаар хангах, агаарын бохирдлыг бууруулахын тулд нүүрсний ДЦС 2, 3 ба 4-ийн хүчин чадлыг 48%-иар нэмэхээр төлөвлөсөн нь одоогийн CO₂eq 7.2 сая тонн дээр 6.1 сая тонн CO₂eq хүлэмжийн хийн хаягдлыг нэмж үйлдвэрлэхээр байна. Түүхий нүүрс шатаахыг хориглож, шахмал түлш хэрэглэх ажлыг яаравчлан эхлүүлэхдээ нөлөөллийн үнэлгээ хийгээгүйн улмаас хүний амь эрсдэхэд хүргэсэн.

Олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа ч хүний эрхэд суурилахгүй, нөлөөллийг урьдчилан үнэлэхгүй, энэ хэмжээнд хохирлыг барагдуулж эрхийг сэргээх хөтөлбөргүй байна. Энэ хүрээнд хэрэгжиж буй хот байгуулалтын хөтөлбөр нь хүн амын төвлөрлийг сааруулах бодлого, 2030 он гэхэд усгүй болох Улаанбаатар хотын төлөвтэй уялдахгүй байна.

Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр баталсан нь Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалттай зөрчилдөж байна. Мөн МУ-ын MNS 4585:2016 стандартаар тогтоосон агаарын чанарын индексийг тооцох аргачлал нь бодит эрсдэлийг нуун дарагдуулахаар байна.

Нутгийн хүн ам зөрчилтэй компанийг хуулийн хариуцлагад татахад шүүх, хууль зүйн туслалцааны хүртээмж аймаг, сумын түвшинд хангалтгүй, шүүхэд компанийн эсрэг нэхэмжлэл гаргахад хэрэг үйлдсэн газарт биш тухай компанийн бүртгэлээр хэргийн харьяалал тогтоож уул уурхайн зөрчлийг ихэвчлэн Улаанбаатарт ирж нэхэмжлэхэд хүрч байгаа нь хүндрэл учруулж байна.

АХБ-ны төслийн нүүлгэлтэд өртсөн “газрын гэрчилгээтэй” 900 гаруй өрх (хажуу айлыг тооцвол 3000-аад өрх)-өөс зөвхөн 130-аад хүн АХБ-нд гомдол гаргаснаар нөхөн олговрын багцаа нэмэгдүүлэх зөвшилцөлд хүрсэн ч нэмэгдүүлж буй хувь хэмжээ нь амьжиргаагаа хадгалах, орон байртай болоход хүрэлцээгүй, шударга биш хэвээр байна.

Үндэсний тодорхойлсон зорилт (NDC)-ын хүлэмжийн хийн ялгарлыг 14 хувиар бууруулах амлалтаас ухарч, нийт 60 сая тонн CO₂eq хүрч одоогийн түвшнийг 2 дахин нэмэгдүүлнэ. Мөн Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр (ЭХДХХ) нь нүүрсний хүчин чадлыг 150% нэмэгдүүлж, нар, салхины эх үүсвэр суурилуулах хүчин чадлыг 65 хувиар бууруулсан нь 2030 он гэхэд эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын 30 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах амлалт биелэхгүйд хүрсэн. Үүний зэрэгцээ ДЦС-аас агаарт хаягдах PM_{2.5} болон бусад элемент нэмэгдэж хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөр байхад СНҮ хийгдээгүй бөгөөд энэ нь ТХЗ-3.9, 13.2-ыг хэрэгжүүлэх амлалттай зөрчилдөж байна.

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын иргэн СГКТ компанийн хууль зөрчиж авсан лицензийн хэргийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд 2018 онд нэхэмжилж, улмаар нэг талдаа 910 км замыг 33 удаа туулж шүүх хэлэлцүүлэгт оролцсон ч нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, хэргийг хаасан.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

- 1) Одоо хэрэгжиж буй эрчим хүч, уул уурхай ба хүнд үйлдвэр, зам тээвэр, бүх дэд бүтцийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд Стратегийн нөлөөллийн үнэлгээ хийж хүний эрхийн болон байгаль орчны конвенциуд, уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН), ТХЗ мөн түүнчлэн БОГҮ-ний тайлан зөвлөмжүүдэд нийцүүлэн сайжруулах;
- 2) Олон улсын стандартад нийцсэн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын үндэсний журам стандарт баталж аймаг, нийслэлийн газар, хот төлөвлөлт, уул уурхай, дэд бүтэц ба аливаа төсөлд лиценз олголтын өмнө нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд багтаан хэрэгжүүлэх;
- 3) Сөрөг нөлөөллийн өндөр эрсдэл (А Category)-тэй төслүүдэд хүний эрхийн нөлөөлөл болон эрхийг хамгаалагчдын эрсдэлийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдүүлэх, хэрэгжүүлэх;
- 4) Зөрчил гарсан, гарч болзошгүй газарт хэргийг хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт бий болгох;
- 5) Байгаль орчны талаарх мэдээлэл, гомдлыг авч хэлэлцэх, шийдвэрлэх эрхтэй, хараат бус байгаль орчны Омбудсперсоны эрх мэдэл бий болгох;
- 6) Уламжлалт нүүдэлч ахуй соёлыг хамгаалах, нүүдэлч хүн амын нүүдэллэн мал маллах зайлшгүй шаардлага ба уламжлалаар зохицуулагдан ирсэн бэлчээрийн эрхийг нь хангах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох үйл ажиллагааг Бизнес ба хүний эрх Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд суулган хэрэгжүүлэх;
- 7) Уул уурхай, эрчим хүч, барилга ба дэд бүтцийн салбарт хамаарах хүний эрүүл мэндэд нөлөөтэй химийн бодисын MNS улсын стандартыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын стандартуудад нийцүүлэн хянан шинэчлэх.



БЭЛГИЙН ЦӨӨНХИЙН ХҮНИЙ ЭРХ (ЛГБТИК)

Монгол Улс нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон Гэрээний хороодоос лесбиан, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, күйр (ЛГБТИК) хүний эрхийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрүүлэх, хамгаалахыг шаардсан 40 гаруй зөвлөмжийг авсан хэдий ч эдгээр зөвлөмж биелэгдээгүйгээс үүдэн ЛГБТИК хүмүүсийн эрх өдөр тутам ноцтойгоор зөрчигдсөөр байна. Монгол Улсын Засгийн газар 2017 оны 7-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулиар бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг хориглох зөвлөмжийг биелүүлсэн. Гэсэн хэдий ч ЛГБТИК хүмүүсийн эсрэг түгээмэл тархсан нийгмийн сөрөг хандлагыг арилгахад эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ дангаараа хангалтгүй юм. Мөн хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг энэ төрлийн гэмт хэргийн асуудлаар ажиллахад нь сургах, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах санаачилга дутмаг байна.

ЛГБТИК ХҮЙ ОЛНЫ ХУВЬД ТҮГЭЭМЭЛ ЗӨРЧИГДӨЖ БҮЙ ЭРХҮҮД:

- Амьд явах
- Халдашгүй дархан байх болон аюулгүй байх
- Хуулиар тэгш хамгаалуулах
- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх
- Сурч боловсрох
- Хөдөлмөрлөх
- Шударга шүүхээр шүүлгэх
- Эрүүдэн шүүлтээс ангид байх
- Хувийн нууцаа хамгаалуулах
- Нийгэм, соёлын амьдралд чөлөөтэй оролцох
- Амьжиргааны зүй зохистой хэм хэмжээгээр хангагдах
- Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах (бие махбод, сэтгэл зүй)
- Гэр бүлтэй байх
- Өмчтэй байх

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

ЛГБТИК хүмүүсийг үл тэвчих, ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх хэлбэрүүд Монголд олон хэлбэрээр илэрсээр байдаг ба энэ хэлбэрүүд нь харилцан уялдаатай учир бие биеэ тэтгэж, ялгаварлан гадуурхалт оршсоор байх бат үндэс болдог. ЛГБТИК хүмүүсийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх хамгаалагдаагүйгээс нэг төрлийн ялгаварлан гадуурхалт бусад ялгаварлалд хүргэснээр амьд явах, бие махбодын хувьд халдашгүй дархан, аюулгүй байх, тэгш хамгаалагдах, шударга шүүхээр шүүлгэх болон зөрчигдсөн эрхээ сэргээлгэх буюу шударга ёс хүртэх эрх, үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх (энэ нь ялангуяа хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд хамаатай) зэрэг үндсэн эрх, эрх чөлөөгөө ЛГБТИК хүмүүс эдлэх боломжгүй байдалд хүргэж байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

2019 оны 9-р сард трансжендэр эмэгтэй болох Н-г зочид буудалд байхад нь хэт үндсэрхэг бүлэг болох “Босоо Хөх Монгол” ТББ нь “ТВ4” телевизийн сувагтай хамтран уг зочид буудал руу нэвтэрч түүнийг дарамталж, хүчээр ярилцлага авсан, дараа нь ярилцлагыг олон нийтэд цацаж, түүний эрхэнд ноцтой халдсан. Тухайн хүмүүс трансжендэр хүмүүсийг цаашид ялгаварлан гадуурхсаар байх тухайгаа болон трансжендэр хүмүүсийг ямар хэлбэрээр гутаан доромжлохоор төлөвлөж байгаагаа олон нийтэд зарласан. Тус ТББ-ын захирал фейсбүүк-т үзэн ядах агуулга бүхий нийтлэлдээ “...бид цаашдаа муусайн нийгмийн хог шаарнуудыг хэлж байгаад ялгаварлан гадуурхаж, яриад байсан эрх чөлөөнд нь халдаж гутаан доромжилж, үсийг нь хусан нүүрийг нь угааж, нүцгэлж зургийг нь авч шившиглэх болно...” гэж нийтэлсэн. Мөн үүний дараа тэд хэвлэлийн бага хурал хийж дахин трансжендэр хүмүүсийг заналхийлсэн.

ЛГБТИК хүмүүс хосоороо амьдарч буйг мэдсэн тохиолдолд тэдэнд орон байр түрээслэхгүй байх, түрээсийн орон байраас хүчээр гаргах асуудал ноцтой байна. ЛГБТИК хүмүүсийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн хэмжээ ноцтой байсаар байгаа нь тэд аюулгүй, халдашгүй байх, шаардлага хангахуйц орон байр, амьжиргааны түвшинтэй байх, ижил хүйсийн хос, эсвэл хосын нэг нь транс хүн байх тохиолдолд тэдний харилцааг үгүйсгэснээр эсвэл хүүхдийг нь үгүйсгэснээр гэр бүл зохиох, өмчтэй байх эрхээ эдэлж чадахгүй байдалд оруулж байна.

2017 онд трансжендэр эмэгтэй М түр саатуулах байрны албан хаагчдын эрүү шүүлтэд өртсөн. Түүнд хүч хэрэглэн цээж болон бэлэг эрхтнийг нь олны өмнө харуулж, хэл амаар доромжилсон. М нь цагдаа нарын ноцтой үзэн ядалтын үйлдлийн эсрэг гомдол гаргасан ч мөрдөн байцаалт хийлгүйгээр хэрэгсэхгүй болгосон. Энэхүү гомдол нь М-ын нөхцөл байдлыг хүндрүүлж, цагдаа нараас дарамт хүлээх эрсдэлд оруулсан.

Эрүүл мэндийн салбарын гетеронорматив хүрээ, салбарын ЛГБТИК хүмүүсийн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, чадавх, хандлага байхгүйгээс үүдэн ЛГБТИК олон нийтийг бүрдүүлэгч дэд олон нийт бүрийн эрүүл мэндийн тодорхой хэрэгцээ хангагдахгүй, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, хүйсийн шилжилттэй холбоотой даавар орлуулах эмчилгээ болон хагалгаанууд эрүүл мэндийн даатгалд ороогүйгээс үүдэн ЛГБТИК хүмүүсийн эрүүл мэндээ бүрэн хамгаалуулах үндэс бүрдээгүй байна.

2019 оны “Тэгш эрхийн төлөө алхалт” жагсаалын үеэр цагдаагийн ажилтан хүүхэдтэй ирсэн хүмүүсийг жагсаалд оролцуулахгүй гэж буцаасан. Мөн цагдаагийн ажилтан нь жагсаалын үеэр хүүхэдтэйгээ ирсэн өөр эмэгтэйг жагсаалаас гарахыг шаардаж маргаан үүсгэсэн.

Гетеронорматив хэм хэмжээ боловсролын тогтолцоонд хүчтэй байсаар байгаа нь ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлж, сурч боловсрох, соёлын болон нийтийн орон зайд байх эрхийг ЛГБТИК хүмүүсийн хувьд эдлэх боломжгүй нөхцөлд хүргэж байна. Монгол Улсын Засгийн газар бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллээр үл ялгаварлан гадуурхах талаар нийгэмд боловсрол түгээх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа огт хийгээгүй.

2016 онд 4-5 өсвөр насны трансжендэр хүүхдүүдтэй христэд итгэгч Б гэх эмэгтэй өөрийгөө сэтгэл зүйч гэж танилцуулан тэднийг “эмчилнэ”, “эдгээж өгнө” хэмээн хууран мэхэлж, ярилцлага, ухуулга хийж тэдний хувь хүний болон эрүүл мэндийн нууцтай холбоотой мэдээллийг авч гэр бүлд нь мэдэгдсэн. Ингэснээр тухайн трансжендэр хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлт байдалд оруулсан.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. ЛГБТИК хүмүүс зэрэг нийгмийн цөөнх бүлгүүдийн нийт гишүүний эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхахын эсрэг цогц хууль тогтоомжийг батлах. Энэ хуулийг батлахдаа төр нь иргэний нийгмийн байгууллагуудтай чухал ач холбогдолтой зөвлөлдөх уулзалтууд хийж, хуулийн хэрэгжилтийг хангах томоохон үүрэг, институцийн баталгаа бүхий бие даасан тэгш байдлыг хангах байгууллага байгуулах ёстой.
2. ЛГБТИК хүмүүсийн дэд олон нийт бүрийн эрүүл мэндийн нөхцөл байдлыг бүрэн тодорхойлох, хэрэгцээнд үндэслэсэн эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ үзүүлэх, ЛГБТИК олон нийтийн дэд олон нийт бүрийн тодорхой өөр өөр хэрэгцээг эрүүл мэндийн даатгалд хамруулах, эрүүл мэндийн салбарт бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр үл ялгаварлах ёс зүйн хэм хэмжээг хуульчлах;
3. Монгол Улсын Засгийн газар нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн насанд хүрсэн, харилцан зөвшилцсөн бүх хүнд гэр бүл зохиох эрхийг нь ялгаварлалгүй эдлүүлэхийн тулд ижил хүйсийн хосууд болон тэдний хүүхдүүдийг үр дүнтэй хамгаалах, гэр бүлийг нь хүлээн зөвшөөрөхийг оролцуулан эрх зүйн шинэчлэлийг хийх;
4. Боловсролын бүх салбарт бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай ялгаварлан гадуурхахгүй байх бүх нийтийн бодлого нэвтрүүлж ЛГБТИК өсвөр насны хүүхдүүд өөрсдийгөө айж эмээлгүйгээр чөлөөтэй илэрхийлж, сурч боловсрох аюулгүй орчныг бие болгох;
5. ЛГБТИК хүй олны эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх болон таниулж хүлээн зөвшөөрүүлэх олон нийтийн сурталчилгааны ажлыг эхлүүлэх.



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR II циклээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр 21 зөвлөмж хүлээн авч, хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан. Эдгээр зөвлөмжийн хэрэгжилтэд тодорхой ахиц гарч, гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцсоноор хохирогчийг хамгаалах хуулийн боломж илүү өргөжсөн.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч хүнд гэмтэх, амиа хорлох болон хүүхэд хохирсон хэрэг өсөх хандлагатай байна.

Төрөөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зардлыг улсын төсөвт тусгайлан тусгаж батлаагүй байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах, олон нийтийн хандлагыг өөрчлөх, мэргэжилтнүүдийг сургах, чадавхжуулах, хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээрх салбар хоорондын зохицуулалт сул байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг хүлээсэн цагдаа, эмч, багш, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг нэгдсэн хөтөлбөр, агуулгаар, тодорхой давтамжтай явуулахгүй байна.

КЕЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Үндэсний статистикийн газрын 2017 оны судалгаагаар Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг нь бие махбодын, арван эмэгтэй тутмын дөрөв нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 2 жилийн хугацаанд 15 хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас амиа алджээ.

Олон улсын байгууллагын төсөл, зарим орон нутгийн санаачилгын хүрээнд байгуулагдсан нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрууд нь санхүүжилтийн эх үүсвэргүйн улмаас тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй байна.

Мэргэжилтнүүд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдолд үр дүнтэй хариу үйлдэл үзүүлж чадахгүй, мөн тогтвортой ажиллахгүй, хүний нөөц дутмаг байна. Тухайлбал, цагдаагийн байгууллага 4585 орон тоо дутуу ажиллаж байна.

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт хангалтгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцахаар заасан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Орон нутагт сургалт явуулах мэргэжлийн багш, сургалтын анги танхим, хэрэглэгдэхүүн, сургалт явуулах багш нарт олгох зардал шийдэгдээгүй.

БАРИМТ

Орон нутагт цагдаа, мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч дутмаг, мэргэжилтнүүд байнга солигдож байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэхэд хүндрэл учруулж байна. Зарим суманд мэргэжлийн нийгмийн ажилтан байхгүй байна.

Мэргэжилтнүүд тогтвортой ажилладаггүй, сонгуулийн дараа байнга солигддог учир хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

UPR тайлан бэлтгэх хүрээнд Өмнөговь, Дорнод, Хөвсгөл, Хэнтий аймагт хийсэн фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс, 2019 оны 6 сар

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардлыг улсын төсөвт тусгайлан суулгаж батлах;
3. Нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байруудын санхүүжилт, тогтвортой үйл ажиллагааг дэмжих;
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах;
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн цагдаа, эмч, багш, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг нэгдсэн хөтөлбөр, агуулгаар, тодорхой давтамжтай явуулах;
6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий цагдаа, нийгмийн ажилтан, эмч, багш зэрэг мэргэжилтнүүдийн орон тоог нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах;
7. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх алба хаагчид болон хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчдын орон тоог нэмэгдүүлэх, техник хангамжийн хүртээмжийг сайжруулах;
8. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй явуулах зардлыг шийдвэрлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах.